



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 15/10 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн өмчөөс шилжүүлсэн 150,869,067.00 (нэг зуун тавин сая найман зуун жаран есөн мянга жаран долоон) төгрөгийн балансын үнэ, 9,642,248.46 (есөн сая зургаан зуун дөчин хоёр мянга хоёр зуун дөчин найман төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий барилга (Ахмад настны Эрүүл мэндийн төв)-ыг төрийн өмчид хүлээн авч хавсралтад заасны дагуу Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Н.Шинэбаяр, Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Н.Гэрэлцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Газар эзэмших эрхийг шилжүүлэн баталгаажуулах, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002908
10-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 04 дүгээр сарын-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

Дорнод аймгийн өмчөөс шилжүүлсэн хөрөнгийг төрийн өмчит хуулийн этгээдэд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх авах байгууллагын нэр
1	Ахмад настны Эрүүл мэндийн төвийн барилга	Дорнод аймгийн Хэрлэн сумын 1-р баг сум	2007	215	м.кв	150,869,067.00	9,642,248.46	141,226,818.54	Дорнод аймгийн Эрүүл мэндийн газар	Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын
НИЙТ ДҮН						150,869,067.00	9,642,248.46	141,226,818.54		
						(нэг зуун тавин сая найман зуун жаран есөн мянга жаран долоон)	(есөн сая зургаан зуун дөчин хоёр мянга хоёр зуун дөчин найман төгрөг дөчин зургаан мөнгө)	(нэг зуун дөчин нэгэн сая хоёр зуун хорин зургаан мянга найман зуун арван найман төгрөг тавин дөрвөн мөнгө)		